

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл ба арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмжөөр хангахад оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт;
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

3.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

Тус үндэсний төв нь “2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 11 зорилтын хүрээнд 98 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгаснаас 24.7% нь тогтмол хийгддэг ажил байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 86.0%

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн зарим арга хэмжээнүүдээс дурдвал: Хүүхэд, эх барих, эмэгтэйчүүдийн өвчний оношилгоонд соронзон резонанст томографийн шинжилгээг (MRI) уртасгасан цагаар ажиллуулж 1300 үйлчлүүлэгчийг хамруулсан, дутуу нярайн уушги гэмтэхээс сэргийлэх өндөр давтамжит аргаар (НФО) амьсгалуулах эмчилгээг НЭЭТ-т бүрэн нэвтрүүлсэн байна.

Гэвч зарим үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хэмжигдэхүйц бус тодорхойлсон, ижил агуулгатай арга хэмжээг хэд хэдэн арга хэмжээ болгон салгаж төлөвлөсөн зэрэг дутагдлууд байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

- Ургийн халдварыг оношлох зорилгоор ураг орчмын шингэнд цитомегаловирусыг илрүүлэх шинжилгээг эхлүүлнэ;
- Хүчилтөрөгч-цусан хангамжийн дутагдлын шалтгаант энцефалопатитай нярайд эрт үед гипотерми (хөргөөх)-ийн эмчилгээг нэвтрүүлэх;
- Хүүхдэд ясны чөмөг шилжүүлэн суулгах мэс заслыг нутагшуулах;
- Хүүхдийн ухархайн хавдрын мэс заслыг тогтмолжуулна;
- Дутуу төрөлтийг үнэлэх оношлох оношилгооны төрлийг нэмэгдүүлнэ;
- Үр шилжүүлэн суулгах эмчилгээний жирэмслэлтийн хувийг нэмэгдүүлнэ;
- Үргүйдэл, нөхөн үржихүйн тусламжид үр хөврөлийн лазер ажилбарыг нэвтрүүлнэ;
- Пренатал оношилгоо, генетик шинжилгээний тоог нэмэгдүүлнэ;
- Хүүхдийн хавдрын цитогенетик шинжилгээг нэмэгдүүлнэ;
- Тусламж, үйлчилгээнд давтан хэрэглэх багаж хэрэгслийг угаах автомат угаалгын машин, төхөөрөмжийг шинэчлэх;

- Зөөлөн эдлэлийг халдваргүйтгэх аппарат, тоног төхөөрөмжийг шинэчлэх;
- Амбулаторийн эмийн санг байгуулан ажиллуулах;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлж урамшуулах;
- Хүүхдийн зөвлөх поликлиникийн стандартад нийцсэн өргөтгөл байр барих;
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тасаг нэгжүүдэд хуваарийн дагуу их засвар хийнэ;
- Гамшиг нийтийг хамарсан үед шаардагдах эд материалын нөөцийг бүрдүүлж хадгалалтыг сайжруулна;

3.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

2024 оны үнэлгээний дундаж 73.8 хувьтай буюу “Хэрэгжих шатандаа” байна. Албан хаагчдын гадаад сургалтын төлөвлөгөө биелсэн ч нийт албан хаагчдын 20-оос дээш хувийг оролцуулах шаардлагатайгаас 6 хувийг хамруулсан, сэтгэл ханамжийн судалгаанд нийт албан хаагчдын 49 хувь хамрагдсан ба үнэлгээ 25 хувьтай байгаа зэрэг хангалтгүй үзүүлэлттэй байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн үнэлгээнд хамрагдах 12 үзүүлэлтээс 6 үзүүлэлтийн зорилтот түвшин журмаар баталгаажсан ба 6 зорилтын хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын үзүүлэлтээр төлөвлөж тайлагнахаас 6 үзүүлэлтийг зорилтот түвшингүй тайлагнасан.

3.3 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

2024 оны жилийн эцсийн байдлаар 23.1 хувь буюу “Хэрэгжилт хангалтгүй” байна.

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал –26.6 хувь буюу Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр зэрэг 5 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 0 хувь буюу Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам зэрэг 6 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 64.6 хувь буюу Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан зэрэг 6 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 0% буюу Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг байршуулаагүй

- Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал – 24.3 хувь буюуОлон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт ;Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт

болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл зэргийг ил тод байршуулаагүй.

Байгууллагын албан ёсны цахим хуудасны тогтмол ажиллагааг хангахгүй, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, цаг хугацаанд нь хийгээгүй, мэдээллүүдийг давхардуулж олон дэд цэсэд байршуулах, мэдээллийг дутуу байршуулах эсвэл бүр байршуулахгүй орхих, мэдээллийг үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой байхаар байршуулаагүй зэрэг дутагдлууд байна. Зарим шалгуур үзүүлэлтийг оновчгүй тайлагнах, мэдээллийг байршуулаагүй атлаа тухайн шалгуур үзүүлэлтийг 100 хувь хэрэгжсэн гэж тайлагнасан нь нийтлэг байна. Мөн байгууллагын нийгмийн сүлжээний хуудсанд мэдээллийг түлхүү байршуулж, байгууллагын албан ёсны цахим хуудасны тогтмол ажиллагааг хангахгүй орхигдуулж байна.

3.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээний дүн 58.6 хувь бөгөөд өмнөх оны түвшнээс сайжраагүй, дунджаас муу дараах үзүүлэлтүүд байна. Үүнд:
 2. Орны фонд ашиглалтын хувь
 3. Задлан шинжилгээний хувь
 4. Эрчимт эмчилгээний орны фонд ашиглалтын хувь
 5. Давтан хэвтэлтийн хувь
 6. Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагсдын тоо
 7. Судалгаа эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан
 8. Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо
 9. Сэлгэн ажиллуулсан эмч, сувилагчийн тоо (хөдөө орон нутаг болон эмнэлэг хооронд)
 10. Байгууллагуудын өрийн хэмжээ /тэрбум төг/
 11. Амьгүй төрөлтийн түвшин, 1 000 төрөлтөд
 12. Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд – төвийн хэмжээнд)
 13. 28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь
 14. Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд - төвийн хэмжээнд)
 15. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд) - төвийн хэмжээнд
 16. Цусны хорт хавдар анх оношлогдсоноос хойш 10-аас дээш жил амьдарсан хүүхдийн эзлэх хувь /5 жилээс дээш амьдарсан/

3.5 Хэрэглэгчийн үнэлгээ

2024 оны жилийн эцсийн байдлаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ дунджаар 82 хувь буюу 4.1 оноо байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу 2024 онд дотооддоо зохион байгуулсан хэрэглэгчийн үнэлгээний тайланг ирүүлээгүй байна.

Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ 2024 онд эрүүл мэндийн байгууллагын амбулаториор үзүүлсэн болон хэвтэн эмчлүүлж, хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдсан нийт үнэлгээнээс түүвэрлэсэн бөгөөд 854 хэрэглэгчийн үнэлгээнээс 605 үнэлгээг түүвэрлэж гаргасан.

Тус үнэлгээнд амбулаторийн үзлэгийн цаг товлолын хүлээгдэл их гэж 38 хувь нь, эм тариа, ороох, боох хэрэглэгдэхүүний хангалт муу байдаг учраас 26 хувь нь гаднаас өөрсдөө авч ирдэг гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Дөрөв. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

4.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ижил агуулгатай арга хэмжээг нэгтгэх, үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох, тогтмол хийгддэг дотоод ажлуудыг бага тусгах нь зүйтэй.

4.2 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах;

4.3 Монгол Улсын “Төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS6285:2017” стандартыг хангах, стандартын дагуу цахим хуудсыг ажиллуулах;

4.4 Байгууллагын албан ёсны цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журам боловсруулж, мөрдөж ажиллах;

4.5 Байгууллагын албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, хугацаанд нь хийж, мэдээллийг үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой байхаар байршуулж хэвших;

4.6 Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг тогтмолжуулах, эрчимжүүлэх;

4.7 Үнэлгээгээр байршуулаагүй, 0 үнэлгээ авсан мэдээллүүдийг бүрэн, ил тод цахим хуудсанд байршуулах;

4.8 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

4.9 Эрүүл мэндийн байгууллагын үзлэгийн цаг товлох үйлчилгээг иргэдэд хүлээгдэл, чирэгдэл үүсгэхгүйгээр зохион байгуулах.

4.10 Эм тариа, ороох, боох хэрэглэгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэхэд анхаарах;

4.11 Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу тайланг хугацаанд нь үнэн, зөв ирүүлэх.

Тав. Нэгдсэн үнэлгээ

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	Жин	Оноо
1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	86.0	0.2	17.2
2	ТАХ-ийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	73.8	0.15	11.1
3	Мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлт	23.1	0.15	3.5
4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт	58.6	0.3	17.6
5	Хэрэглэгчийн үнэлгээ	82.0	0.2	16.4
6	Ерөнхий үзүүлэлт			65.7

Эрүүл мэндийн яам
2025 оны 04 дүгээр сар

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв					
№	Шалгуур үзүүлэлт	Улсын дундаж	ЭМЯ-ны харьяа байгууллагын дундаж	2023	2024
Нийтлэг үзүүлэлт					
1	Орны фонд ашиглалтын хувь	66.1	77.2	87.2	89.2
2	Дундаж ор хоног	6.85	7.4	6.6	6.5
3	Эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь /8-24 цагийн дотор/	11.8	6.6	2.3	0.8
4	Задлан шинжилгээний хувь	55.0	60.3	98.2	75.2
5	Үндсэн оношийн зөрүүний хувь	6.4	2.2	5.2	0.3
6	Эрчимт эмчилгээний орны фонд ашиглалтын %		75.1	96.8	91.8
7	Давтан хагалгааны хувь		0.8	0.7	0.4
8	Мэс заслын дараах хүндрэлийн хувь		1.4	0.4	0.5
9	Давтан хэвтэлтийн хувь		17.1	11.5	14.5
10	Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагсдын тоо			264.0	209.0
11	-Судалгаа эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан			6.0	2.0
12	Хэвлэгдсэн сэтгүүл болон хэвлэл			3.0	11.0
13	Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо			4	2
14	Сэлгэн ажиллуулсан эмч, сувилагчийн тоо (хөдөө орон нутаг болон эмнэлэг хооронд)			181	55
15	Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь			85.8	85.6
16	Тухайн жил тасралтгүй сургалтын кредитын шаардлага хангасан эмч			100	100
17	Сувилагч			100	100
18	Эх баригч			100	100
19	Байгууллагуудын өрийн хэмжээ /тэрбум төг/				5.3
Өвөрмөц үзүүлэлтүүд					
1	Эмчилгээ, оношилгоо, сувилахуйн тусламж үйлчилгээнд шинэ арга технологи нэвтрүүлсэн тоо, шинэ санаачлага			11	26
2	Эмнэлгээр үйлчлүүлэх үедээ унаж, гэмтсэн тохиолдлын тоо			2	0
3	Амьгүй төрөлтийн түвшин, 1 000 төрөлтөд		5.0	12.2	8.7
4	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд – төвийн хэмжээнд)		22.5	38.5	22.6
5	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь			87.3	81.8
6	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд - төвийн хэмжээнд)		702	274	273
7	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд) - төвийн хэмжээнд		877	300	313
8	Цусны хорт хавдар анх оношлогдсоноос хойш 10-аас дээш жил амьдарсан хүүхдийн эзлэх хувь /5 жилээс дээш амьдарсан/			0	0
9	Уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)			1.2	1
10	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)		0	0.00	0
11	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)		0	0.00	0
12	Цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)		0.03	0.01	0
Нэгдсэн үнэлгээ			58.6		